1. **<u>Олон улсын гэрээ, конвенци</u>**

КИОТО КОНВЕНЦИ ТУСГАЙ ХАВСРАЛТ J ЗААВАР 2 ДУГААР БҮЛЭГ "ШУУДАН ТЭЭВЭР"

Шуудан нь хувийн болон худалдаа арилжааны харилцаанд мэндчилгээ, мэдээлэл илгээхээс гадна бас бэлэг дурсгалын зүйлс болон бусад бараа илгээхэд хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга хэрэгслийн нэг нь цаг ямагт байсаар ирсэн.

Гаалийн байгууллага барааг өөр бусад арга замаар улсын хилээр оруулж, гаргахад хяналт тавьдагийн нэгэн адилаар олон улсын шуудан тээвэрт бас хяналт тавьж оролцох шаардлагатай болдог. Учир нь гаалийн байгууллага холбогдох гаалийн болон бусад татвар төлөх нөхцөлийг бүрдүүлэх бүрдүүлэх, импорт, экспортын хориг, хязгаарлалтыг хэрэгжүүлэх, ерөнхийдөө өөрөө хэрэгжилтэд нь хяналт тавих ёстой хууль тогтоомж, дүрэм журмыг сахиж мөрдөх явдлыг хангах ёстой байдаг. Түүний зэрэгцээ гаалийн байгууллага эрсдэл тооцох арга техник /арга ажиллагаа/ ашиглан хяналт шалгалтаа аль болох хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлзэнэ.

Бараг бүх улс оронд шуудангийн байгууллага нь төрийн болон хувийн эзэмшлээс үл хамааран Дэлхийн шуудангийн холбооны актуудаар зохицуулсан олон улсын үйлчилгээг үзүүлдэг.

ТОДОРХОЙЛОЛТ

E1/F1 **"CN22/23"** гэж Дэлхийн шуудангийн холбооны одоо мөрдөж буй актуудад заасан, шуудан илгээмжийг мэдүүлэх зориулалттай тусгай маягтыг хэлнэ.

E2/F3 **"Шуудан илгээмжид хамаарах гаалийн ёс журмын ажиллагаа"** гэж шуудан тээвэртэй холбогдуулан сонирхогч тал болон гаалийн байгууллагаас хийж гүйцэтгэвэл зохих бүхий л үйл ажиллагааг хэлнэ,

E3/F2 **"Шуудан илгээмж"** гэж Дэлхийн шуудангийн холбооны одоо мөрдөж буй актуудад заасан, шуудангийн байгууллагын шугамаар, эсхүл түүний төлөө тээвэрлэж буй захидал болон илгээлтийг,

E4/F5 **"шуудангийн байгууллага"** гэж Олон улсын шуудангийн холбооны одоо мөрдөж буй актуудаар зохицуулагдах олон улсын үйлчилгээг үзүүлэхээр засгийн газраас эрх авсан төрийн, эсхүл хувийн өмчийн байгууллагыг хэлнэ.

E5/F4 **"Дэлхийн шуудангийн холбоо"** гэж Бернийн хэлэлцээрээр 1874 онд "Шуудангийн ерөнхий холбоо" нэртэйгээр байгуулагдаж, 1878 оноос "Дэлхийн шуудангийн холбоо" гэдэг нэртэй болж, 1948 оноос Нэгдсэн Үндэстний байгууллагын төрөлжсөн байгууллага болсон Засгийн газар хоорондын байгууллагыг хэлнэ.

Шуудангийн байгууллага нь шуудан илгээмжийг тээвэрлэх, хадгалах, мөн гаалийн байгууллагад үзүүлэх үүрэг хүлээдэг бөгөөд гаалийн байгууллагын хүсэлтээр гаалийн хяналт шалгалт хийлгэх зорилгоор тэдгээрийг задалж болно.

Шуудан илгээмжийн гаалийн бүрдүүлэлтийг хүлээн авагч улсад түргэн шуурхай хийж гүйцэтгэхэд тус дөхөм болох үүднээс илгээгч улсын шуудангийн байгууллага нь CN 22 гэсэн шошго болон CN23 гэсэн мэдүүлэг байгаа эсэхийг, мөн тэдгээрийг зөв, бүрэн бөглөсөн эсэхийг заавал шалгах ёстой байдаг. Ялангуяа илгээгч гарын үсэг зурсан эсэхийг заавал нягтлах хэрэгтэй. Мэдүүлэг байхгүй, эсхүл дутуу бөглөсөн нь илэрхий байх тохиолдолд шуудангийн байгууллага илгээгчид гаалийн холбогдох дүрэм журмыг танилцуулж, шаардлагатай бол уг илгээмжийг хүлээн авахаас татгалзаж болно.

Шуудангийн байгууллага шуудангаар импортолж буй барааны бүрдүүлэлтэд дараах 3 түвшинд оролцох боломжтой:

а. Шуудангийн байгууллагын үүрэг нь бүрдүүлэлт хийх шаардлагатай илгээмжийг гаалийн байгууллагад танилцуулахаар хязгаарлагдана.

б. Гаалийн байгууллагын хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд хийгддэг тодорхой ажлуудыг шуудангийн байгууллага гаалийн хяналт дор хийж гүйцэтгэнэ.

с. Шуудангийн байгууллага нь ялангуяа буухиа илгээмжийн хувьд гаалийн бүрдүүлэлтийн агентын үүрэг гүйцэтгэнэ.

Шуудан илгээмжийн бүрдүүлэлт гаалийн байгууллагаар дамжин “автомат”-аар, өөрөөр хэлбэл, илгээгчийн үйлдсэн CN22 болон CN23 мэдүүлгүүд болон бусад бичиг баримтын үндсэн дээр хийгдэнэ.

Хэрэв илгээмж нь CN22 гэсэн шошготой эсвэл түүнийг CN23 гэсэн мэдүүлэг дагалдаж байгаа бол түүнд хамаарах бүрдүүлэлтийг шуудангийн байгууллага гаалийн байгууллагаар дамжуулан хийж гүйцэтгэнэ. Хэрэв эдгээр бичиг баримт байхгүй бол уг илгээмжийг гаалийн байгууллагаар шийдүүлэхээр түүнд гаргаж танилцуулна.



Киото конвенцийн тусгай хавсралт j заавар
2 дугаар бүлэгт

Шуудан тээвэр нь:

Шуудан нь хувийн болон худалдаа арилжааны харилцаанд мэндчилгээ, мэдээлэл илгээхээс гадна бас бэлэг дурсгалын зүйлс болон бусад бараа илгээхэд хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга хэрэгслийн нэг нь цаг ямагт байсаар ирсэн.

Киото конвенцийн тусгай хавсралт j заавар
2 дугаар бүлэгт

Тухайн шуудангийн байгууллага уг илгээмж нь арилжааны аливаа үнэ цэнэтэй эсэхийг, эсхүл өчүүхэн бага үнэ цэнэтэй эсэхийг, мөн гаалийн татваргүй оруулж болох эсэхийг шийднэ.

Шуудангийн ажилтнууд татвар ногдуулах болон ногдуулахгүй барааг *гаалийн байгууллагын хяналтан дор* ялгаж салгах бөгөөд гаалийн байгууллага хүндрэлтэй тохиолдолд шуудангийн байгууллагад туслалцаа үзүүлэх үүрэгтэй байна.

Киото конвенцийн тусгай хавсралт j заавар 2 дугаар бүлэгт

Гаалийн байгууллага өөртөө ямар шуудан илгээмж үзүүлэх болон тэдгээрийг хэрхэн үзүүлэхийг шуудангийн холбогдох байгууллагад зааж өгөхийг шаардана.

Мөн зөвхөн ямар илгээмжийг гаргаж үзүүлэхийг зааж өгөх боломж олгоод зогсохгүй, бас шалгаж үзэх илгээмжийг хэрхэн үзүүлж, танилцуулахыг зааж өгөх боломж олгож байгаа бөгөөд үүнтэй холбогдон гардаг практик хүндрэлүүд арилах замыг нээн өгч байгаа юм.